

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага

MNS 0000:0000

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Улаанбаатар хот  
2024 он

**MNS 0000:0000**

**Өмнөх үг**

Стандарт, хэмжил зүйн газар (Цаашид СХЗГ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд Монгол улсын стандарт боловсруулах ажлыг тус байгууллагын дэргэдэх мэргэжлийн сайн дурын ажлын хэсгээс бүрдсэн техникийн хороодоор дамжуулан гүйцэтгэдэг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн хуралдааны тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Н.Баярмаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Ж.Азжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого зохицуулалт хариуцсан шинжээч

А.Батхишиг (PhD), Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны сургуулийн харьяа Нийгмийн ажлын инновац, туршилт судалгааны төвийн захирал

Ш.Батсүх, Доктор (Sc.D), профессор, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн

М.Чанцалсүрэн, Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны сургуулийн харьяа Нийгмийн ажлын инновац, туршилт судалгааны төвийн гишүүн

Э.Дуламсүрэн, Хүүхэд хамгааллын зөвлөх

Д.Ренчиндорж, Хуулийн зөвлөх

А.Тайванжаргал, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн менежер, сэтгэл судлаач нар боловсруулсан.

Стандарт үзлэгийг 5 жил тутамд хийх боловч шинжлэх ухаан, техникийн түвшинг дээшлүүлэхээр дахин хянах асуудал хугацааны хувьд нээлттэй байна.

**Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)**

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х-48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

Web: [www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn)

E-mail: [standardinform@masm.gov.mn](mailto:standardinform@masm.gov.mn)

© СХЗГ, 2024

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 00.000.00

Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага	MNS 0000:0000
Common requirements for child protection services in educational settings	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 00 сарын 00-ны өдрийн 000 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2024 оны 00 дугаар сарын 00-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

## 1. Зорилго

Стандартын зорилго нь боловсролын орчны хүүхэд хамгааллын үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэхэд оршино. Ингэснээр хүүхэд боловсролын орчинд эрүүл, аюулгүй, амгалан тайван сурч, хөгжих, хамгаалагдах нөхцөл бүрдэх болно.

## 2. Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандарт нь сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн орчинд сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг өмчийн бүх хэлбэрийн байгууллагыг хамрах ба үүнийг цэцэрлэг, сургуулийн хүүхэд хамгааллын баг дагаж мөрдөнө.

## 3. Норматив эшлэл

Энэ стандартын үзэл санаа нь Олон улсын болон Монгол улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичигт суурилсан бөгөөд энэ стандартад иш татаж хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

Олон улсын эрх зүйн баримт бичиг:

- Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ), 1948
- Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭК), 1990
- Олон улсын нийгмийн ажлын холбоо (ОУНАХ) Нийгмийн ажлын боловсрол ба сургалтын дэлхийн стандарт, 2020

Манай улсын холбогдох стандарт, дүрэм журам:

- MNS 6949:2021, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага
- MNS 6799:2019, Сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага

- Боловсролын байгууллагын сургалтын орчин дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам, 2018 он
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам, 2020 он
- Монголын Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм, 2020
- Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого, 2020 он
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, 2021 он
- Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, 2022 он

#### **4. Нэр томьёо, тайлбар**

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

##### **4.1**

##### **Сургалтын орчин**

Боловсролын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-д заасан “Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцааг”

##### **4.2**

##### **Хүүхэд хамгаалал**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д заасан “Нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг”

##### **4.3**

##### **Хүүхэд хамгааллын үйлчилгээ**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасан “Хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг”

##### **4.4**

##### **Нийгмийн ажлын шууд үйлчилгээ**

Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлагын 4.7.1-д заасан “Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай хувь хүн, гэр бүл, бүлэгтэй шууд харилцах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах”

##### **4.5**

##### **Нийгмийн ажлын шууд бус үйлчилгээ**

Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлагын 4.7.2-д заасан “Нийгэм, хүмүүсийн сайн сайхан байдлыг хангах нийгмийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, шаардлагатай хөрөнгө нөөцийг босгох, чадавх бэхжүүлэх, хууль эрх зүйн тогтолцоонд нөлөөлөх, хамтын ажиллагаа түншлэлийг өргөтгөх, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажлын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагааг”

##### **4.6**

#### **Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д заасан “а. амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан хүүхэд; б.хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх нөхцөлд байгаа хүүхэд; в.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд;

г.гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд”-г.

#### **4.7**

##### **Хүүхэд**

18 хүртэлх насны бүх хүнийг хүүхэд<sup>1</sup>

#### **4.8**

##### **Суралцагч**

Боловсролын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д заасан “Боловсролын сургалтын байгууллагад албан ёсоор суралцаж байгаа хүнийг”

#### **4.9**

##### **Ялгаатай хэрэгцээ**

Боловсролын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.24-д заасан “Хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг”

#### **4.10**

##### **Хүүхдийн эсрэг хүчирхийлэл**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д заасан “Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг”

#### **4.11**

##### **Хүүхэд хамгааллын баг**

“Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, дээрэлхэл, дарамтаас хамгаалж хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх мэргэжлийн үйлчилгээг зохион байгуулдаг, хүүхдийн аюулгүй байдал, эрхийг хамгаалах, тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангах зорилготой мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй баг”

**Тайлбар:** Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогод тусгагдсан хүүхэд хамгааллын багийн чиг үүргийн дагуу тодорхойлсон болно.

#### **4.12**

##### **Кейс менежмент**

---

<sup>1</sup> Хүүхдийн эрхийн тухай конвенц

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-д заасан “Хүүхэд, гэр бүлд чиглэсэн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхой үе шатаар хүргэх, зохицуулах, хяналт тавих мэргэжлийн үйл ажиллагааг”

## 5. Ангилал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/218 тоот тушаалаар батлагдсан Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын 1.2-д заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээг дараах түвшинд ангилна.

- A. **Шуурхай тусламжийн үйлчилгээ:** Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, холбон зуучлах үйлчилгээ багтана.
- B. **Хамгаалах болон нөхөн сэргээх үйлчилгээ:** Хүүхдийг гэр бүлийнх нь орчинд хамгаалах нөхөн сэргээх болон хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ гэсэн хэлбэртэй байна. Үүнд хямралыг даван туулахад туслах, дэмжих, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн цочрол, гэмтлийг даван туулахад туслах, танин мэдэхүй-зан үйлийн шаталсан зөвлөгөө өгөх, чадавхжуулах, дэмжих бүлэг багтана.
- C. **Урьдчилан сэргийлэх үйлчилгээ:** Энэ үйлчилгээнд хүүхдэд, эцэг эх, гэр бүл, олон нийтэд чиглэсэн болон хүний нөөцийг чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажил багтана.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээг олон төрлийн мэргэжилтнээс бүрдсэн баг үзүүлэх бөгөөд энэ нь дараах төрлийн үйлчилгээнүүд байна.

- A. Нийгмийн ажлын үйлчилгээ
- B. Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ
- C. Эрүүл мэндийн үйлчилгээ
- D. Сурч боловсрох, хөгжүүлэх үйлчилгээ.

## 6. Ерөнхий шаардлага

### 6.1 Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын багт тавигдах ерөнхий шаардлага

**6.1.1.** Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын баг нь ерөнхий боловсролын сургууль бол сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сургалтын менежер, эмч, сэтгэл зүйч, багш нарын төлөөлөл, дотуур байрны багш (хэрэв дотуур байртай бол), эцэг эхийн төлөөллөөс; сургуулийн өмнөх боловсролын байгууллага бол цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сэтгэл зүйч эсвэл нийгмийн ажилтан (тухайн цэцэрлэгийн хүний нөөцөөс хамаарч), багш ажилчид, эцэг эхийн төлөөллөөс тус тус бүрдэнэ.

**6.1.2.** Хүүхэд хамгааллын багийн гишүүд нь хүүхдийн эрх зөрчсөн, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн нь нотлогдсон, ёс зүйн зөрчил гаргасан түүхгүй байна.

**6.1.3.** Хүүхэд хамгааллын баг нь хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол улсын хууль, журам, нийтлэг шаардлага, стандарт, удирдамжийг мөрдөн ажиллана.

**6.1.4.** Хүүхэд хамгааллын баг нь хүүхэд хамгааллын үйлчилгээний бодлого, хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө, тогтмол болон яаралтай хуралдах хуваарьтай байна.

**6.1.5.** Хүүхэд хамгааллын баг нь эрсдэлт нөхцөлд байгаа болон эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, боловсролын орчны аюулгүй байдлыг тандах үнэлгээ, судалгааны ажилд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

**6.1.6.** Хүүхэд хамгааллын баг нь боловсролын орчинд хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулна.

**6.1.7.** Хүүхэд хамгааллын баг нь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох журам, нийтлэг шаардлагад заасны дагуу мэдээлэл, кейс файлыг хөтлөх, хадгалах, архивлах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг хариуцна.

**6.1.8.** Хүүхэд хамгааллын баг нь боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх тоо мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих, түгээх ажлыг зохион байгуулна.

**6.1.9.** Хүүхэд хамгааллын баг нь боловсролын орчин дахь удирдлага, багш, ажилтан, эцэг эх, орон нутгийн холбогдох мэргэжлийн болон олон нийтийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

**6.1.10.** Хүүхэд хамгааллын багийн ахлагч хүүхэд хамгааллын багийн гишүүдэд зориулсан хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийн талаарх сургалт, туршлага солилцох хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулна.

**6.1.11.** Хүүхэд хамгааллын багийн ахлагч хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах нээлттэй суваг цэцэрлэг, сургуулийн орчинд ажиллуулах, гомдол, мэдээллийн мөрөөр шуурхай арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

**6.1.12.** Хүүхэд хамгааллын баг нь хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой нууцыг чанд хадгална.

## **6.2 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага**

**6.2.1.** Хүүхэд хамгааллын үйлчилгээг цэцэрлэг, сургуулийн хүүхэд хамгааллын баг үзүүлнэ.

**6.2.2.** Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хүүхдийн насны онцлог тэр дундаа бие бялдар, нийгэм-сэтгэл хөдлөл, танин мэдэхүйн онцлог, ялгаатай хэрэгцээнд нийцсэн байна.

**6.2.3.** Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн бүх хүүхдэд хамааралтай бөгөөд тухайн байгууллагын сургалтын үйл ажиллагаатай уялдсан байна.

**6.2.4.** Хүүхэд хамгааллын үйлчилгээг *шуурхай тусламж, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх* гэсэн гурван түвшинд үзүүлэх бөгөөд эдгээрт нийгмийн ажлын, нийгэм сэтгэл зүйн, эрүүл мэндийн, сурч боловсрох, хөгжүүлэх зэрэг холбогдох салбарын мэргэжлийн үйлчилгээг багтаасан байна.

**6.2.5.** Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь үл хайхрах, ялангуяа боловсролын үл хайхрах, сэтгэл зүйн дарамт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт, бие махбодын хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрээс суралцагч, хүүхдийг цаг алдалгүй хамгаалах, шаардлагатай хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

**6.2.6.** Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хүүхдийн эрх, ялгаатай хэрэгцээнд хүндэтгэлтэй хандаж, аюулгүй байдал, нууцлалыг хадгалж, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхгүй, олон нийтийн сүлжээнд нийтлэхгүй, хүүхдэд хор хөнөөл учруулахгүй байна.

**6.2.7.** Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ “Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага”-д тусгасан кейс менежментийн үе шатын дагуу үзүүлж, үйлчилгээний мэдээллийн санд бүртгэнэ.

**6.2.8.** Хүүхэд хамгааллын багийн ахлагч гишүүдийг үүрэг, хариуцлагын дагуу чиглүүлж ажиллана.

### **6.3 Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, тавигдах ерөнхий шаардлага**

#### **6.3.1 Шуурхай тусламжийн үйлчилгээ**

- Эрсдэлт нөхцөлд байгаа болон эрсдэлд өртөж болзошгүй талаарх мэдээллийг хүүхэд хамгааллын баг хүлээн авсан бол шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлнэ.
- Шуурхай тусламжийн үйлчилгээнд мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, холбон зуучлах үйлчилгээ багтана.<sup>2</sup>
- Эрсдэл өндөртэй нь тогтоогдсон хүүхдэд эмнэлгийн шуурхай тусламж, хууль эрх зүйн шуурхай тусламж, нийгмийн ажлын шуурхай тусламж, сэтгэл зүйн шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлнэ.
- Шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэхдээ хүүхдийн насны онцлог, ялгаатай хэрэгцээ, учирсан хохирол, нөхцөл байдлыг харгалзан хүүхдэд хор хохирол учруулахгүй байна.
- Хүүхэд хамгааллын баг хүүхдийн эрх зөрчигдсөн, эрсдэлд байгааг таамагласан, мэдсэн, илрүүлсэн талаарх мэдээллийг олон талт хэлбэрээр /амаар, бичгээр, утсаар, цахимаар/ хүлээн авна.
- Шуурхай тусламжийн үйлчилгээнд кейс менежментийг нийгмийн ажилтан удирдан чиглүүлж ажиллана.
- Шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэхдээ сум, хорооны хамтарсан баг болон харьяа гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллана.
- Хүүхэд хамгааллын баг нь боловсролын болон гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлтэй хүүхдийн эрсдэлийн түвшинг үнэлж хамтарсан багт холбон зуучилж ажиллана.

#### **6.3.2 Хамгаалах болон нөхөн сэргээх үйлчилгээ**

- Боловсролын орчин дахь бүх хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх ба хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй ганцаарчлан ажиллах, гэр бүл болон хүүхдийн бүлэгтэй ажиллах, байгууллага, олон нийттэй ажиллах зэрэг нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйгээр хүргэнэ.<sup>3</sup>
- Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хүчирхийллийн хохирогч хүүхдийг хямралыг даван туулахад туслах, дэмжих, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн цочрол, гэмтлийг даван туулахад туслах, танин мэдэхүй-зан үйлийн шаталсан зөвлөгөө өгөх, чадавхжуулах, дэмжих бүлэг зэрэг арга зүйг дангаар буюу хослуулан хэрэглэнэ.
- Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ хүүхдийн насны онцлог, ялгаатай хэрэгцээ, үйлчилгээний хэлбэр, нөхцөл байдлыг харгалзан хүүхдэд хор хохирол учруулахгүй байна.

<sup>2</sup> Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.1.1

<sup>3</sup> Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.3



- Боловсролын орчин дахь ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөртэй байна.
- Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ сум, хорооны хамтарсан баг болон харьяа гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллана.
- Хүүхэд хамгааллын баг нь нийгмийн ажил, нийгэм сэтгэл зүй, боловсрол, эрүүл мэнд, хууль зүй, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд үйлчлүүлэгчийг хамтарсан баг, холбогдох улсын байгууллага, тухайн үйлчлүүлэгчид тулгамдсан асуудлаар мэргэшсэн байгууллагад холбон зуучилна.

### **6.3.3 Урьдчилан сэргийлэх үйлчилгээ**

- Боловсролын орчин дахь бүх хүүхдэд урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэх ба хүүхдэд чиглэсэн, эцэг эх, гэр бүлд чиглэсэн, олон нийтэд чиглэсэн, боловсролын орчин дахь хүний нөөцийг чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажил багтана.
- Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь тухайн зорилтот бүлгийн онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж, аюулгүй байдлыг бүрдүүлсэн байна.
- Урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлын агуулга нь хүүхдэд бол хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний хөгжил, оролцоог дэмжих агуулгатай; эцэг эх, гэр бүлд чиглэсэн бол хүний эрх, жендэр, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон өсгөн хүмүүжүүлэх, амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох агуулгатай; олон нийтэд чиглэсэн бол хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага, соёлыг бэхжүүлэх агуулгатай; хүүхэд хамгааллын салбарын болон салбар дундын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулахад чиглэсэн бол салбар дундын зохицуулалтыг хангах сургалт, нөлөөллийн ажил байна.<sup>4</sup>
- Урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэхдээ нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хуульч, өмгөөлөгч, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшсэн байгууллагаас дэмжлэг авч хамтран ажиллана.
- Урьдчилан сэргийлэх үйлчилгээнд эцэг эхийн зөвлөл, эцэг эхийн төлөөллийн үүрэг оролцоо, санал санаачилгыг нэмэгдүүлэн, хамтран ажиллана.
- Боловсролын орчинд багш, ажилтныг шинээр ажилд сонгон шалгаруулж авах журамдаа хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчил, гэмт хэрэгт холбогдсон эсэхийг холбогдох бичигт баримтад үндэслэн нягтлан шалгах тухай тусгана.
- Боловсролын орчинд гаднаас судлаач, багш, туршлага судлах болон байгууллагын засвар үйлчилгээтэй холбоотой мэргэжилтэн ирж ажиллах үед хүүхэд хамгааллын бодлого, журмыг танилцуулна.

## **7. Тусгай шаардлага**

### **7.1 Нийгмийн ажлын үйлчилгээнд тавигдах тусгай шаардлага**

- Нийгмийн ажлын үйлчилгээг сургуулийн нийгмийн ажилтан үзүүлнэ.
- Нийгмийн ажлын үйлчилгээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх, хөгжил, оролцоог дэмжих, суралцах үйл явцад нь тулгарсан хямрал, бэрхшээлийг даван туулахад

<sup>4</sup> Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4 дэх заалтууд

туслах, нөөц боломжтой холбох зэрэг нийгмийн ажлын шууд ба шууд бус үйлчилгээ багтана.

- Нийгмийн ажилтан нь хүүхэдтэй ганцаарчлан уулзах, хүүхдийн жижиг бүлгээр ажиллах зэрэг нийгмийн ажлын шууд үйлчилгээ үзүүлэх хүүхдэд ээлтэй, аюулгүй байдлыг хангах орчныг бүрдүүлсэн өрөөтэй байна.
- Нийгмийн ажлын үйлчилгээ нь үйлчлүүлэгч харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээг хүргэх, хэрэгжүүлэх, үйлчилгээг үнэлэх, үйлчилгээг хаах үе шаттай байна.
- Нийгмийн ажлын үйлчилгээ нь шаардлагатай тохиолдолд кейс менежментийн үе шат, үйл явцын дагуу явагдана.
- Нийгмийн ажилтан нь кейс менежментийн явцад үйлчлүүлэгчийн мэдээллийг тавигдах шаардлагын дагуу тухай бүрд хөтлөх, цаас эсхүл цахим хэлбэрээр тэмдэглэж, архивын ажлын үндсэн зааврын дагуу кейс файлыг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангаж ажиллана.<sup>5</sup>
- Кейс менежмент хийсэн нийгмийн ажилтан нь хүүхдийн мэдээллийг хүүхэд хамгааллын багт өгч ажиллана.
- Нийгмийн ажилтан нь нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагын уулзалт, хэлэлцүүлэгт тогтмол хамрагддаг байна.
- Нийгмийн ажлын үйлчилгээнээс гадна нэмэлт бусад мэргэжлийн үйлчилгээ шаардлагатай хүүхдийг сургуулийн хүүхэд хамгааллын баг болон хамтарсан багтай холбон зуучилж, үйлчлүүлэгчийн мэдээллийг холбон зуучлах маягтын дагуу шилжүүлнэ.

## **7.2 Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээнд тавигдах тусгай шаардлага**

- Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг боловсролын сэтгэл зүйч үзүүлж, чиглүүлж, зохион байгуулна.
- Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээнд хүүхдийн хөгжил, сэтгэл зүйн тулгамдсан асуудал, сэтгэц зан үйлийн төлөв байдлыг үнэлэх, оношлох, дүгнэлт гаргах, сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх, сэтгэл зүйн сургалт зэрэг үйлчилгээ багтана.
- Боловсролын сэтгэл зүйч нь хүүхэдтэй ганцаарчлан уулзах, хүүхдийн жижиг бүлгээр ажиллах зэрэг сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх хүүхдэд ээлтэй, аюулгүй байдлыг хангах орчныг бүрдүүлсэн өрөөтэй байна.
- Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн сэтгэл зүйч нь сэтгэл зүйн үйлчилгээний мэдээллийн сантай байх бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох мэдээллийг хүүхэд хамгааллын багт өгч хамтран ажиллана.
- Сэтгэл зүйч нь мэргэжлийн удирдлагаар хангагдах ганцаарчилсан болон бүлгийн уулзалтуудад тогтмол хамрагддаг байна.
- Сэтгэл зүйн үйлчилгээнээс гадна нэмэлт бусад мэргэжлийн үйлчилгээ шаардлагатай хүүхдийг хүүхэд хамгааллын баг болон хамтарсан багтай холбон зуучилж, үйлчлүүлэгчийн мэдээллийг холбон зуучлах маягтын дагуу шилжүүлнэ.

## **7.3 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах тусгай шаардлага**

- Эрүүл мэндийн үйлчилгээг эмч үзүүлэх ба хүүхдүүдийг эрүүл мэндийн асуудлаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

---

<sup>5</sup> Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлагын 6.2.8

- Эрүүл мэндийн үйлчилгээнд хүүхдэд эмнэлгийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулах үйлчилгээ багтана.
- Боловсролын орчны ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, халдваргүйжүүлэлт, холбогдох стандартын хэрэгжилт зэрэг хүүхэд сурч боловсрох, хөгжих аюулгүй орчны шаардлага хангаж буйд хяналт тавин эрсдэл байгаа тохиолдолд хүүхэд хамгааллын багт мэдэгдэж, шийдвэрлэх арга хэмжээ авна.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнээс гадна хоёр дахь болон гурав дахь шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай, эсхүл бусад мэргэжилтний тусламж, үйлчилгээ шаардлагатай бол хүүхдийг холбогдох эмнэлэг, сургуулийн хүүхэд хамгааллын баг болон хамтарсан багтай холбон зуучилж, үйлчлүүлэгчийн мэдээллийг холбон зуучлах маягтын дагуу шилжүүлнэ.

#### **7.4 Сурч боловсрох, хөгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээнд тавигдах тусгай шаардлага**

- Сурч боловсрох, хөгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээг цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн сургалтын менежер, багш нарын төлөөлөл зохион байгуулж ажиллана.
- Сургалтын болон хөгжүүлэх, танхимын болон хичээлээс гадуурх бүх үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын асуудлыг харгалзан үзэж, хүүхдийн аюулгүй байдлыг хангана.
- Эрсдэлт нөхцөлд байгаа болон эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийг тасралтгүй сурч боловсрох, хөгжих үйл явцыг дэмжих ба сургалтын үйл ажиллагаанаас хоцорсон, завсардсан тохиолдолд шалтгаан, нөхцөл байдлыг тодруулж, хүүхдийн боловсролын бичиг баримтад үндэслэн суралцах түвшин, анги, хэлбэрийг тодорхойлно.
- Хүүхдийн боловсролын баримт бичгийг хянаж, зөрчлийг арилгаж, нөхөн олгоно.
- Сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай материал, хэрэглэгдэхүүний зардлыг байгууллагын төсөвт нэмж оруулан шийдвэрлэнэ.
- Тусгай хэрэгцээт хүүхдийн онцлогт тохирсон хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.

#### **8. Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээнд хориглох зүйл**

- 8.1.** Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхдийг хүчирхийлэл, аюул, эрсдэлээс хамгаалахгүй байх;
- 8.2.** Хүүхэд хамгааллын үйлчилгээ хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнд нийцэхгүй байх;
- 8.3.** Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хүүхдийн нэр төр, хувийн халдашгүй байдал, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалаагүй, аюулгүй байдлыг ханган ажиллаагүй байх;
- 8.4.** Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд, эрсдэлт бүлгийн хүүхдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлэхгүй байх;
- 8.5.** Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд, эрсдэлт бүлгийн хүүхдийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлахгүй, хамруулахгүй байх;
- 8.6.** Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой нууцлалыг хууль зааснаас бусад тохиолдлоор задруулах;
- 8.7.** Хүүхэд хамгааллын үйлчилгээнд үр дүнгүй арга техник ашиглах.

## ТӨГСӨВ.

### Ном зүй

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2024
3. Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016
4. Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016
5. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль (шинэчилсэн найруулга), 2023
6. Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга), 2023
7. Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021
8. Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль (шинэчилсэн найруулга), 2020
9. Монгол улсын Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, 2019
10. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт (БСШУС)-ын сайдын 2018 оны 5 сарын 1 өдрийн А/239 тушаалаар “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”
11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/218 тоот тушаал “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”
12. Монгол Улсын БСШУС-ын сайдын 2018 оны 7 сарын 31-ний өдрийн А/479 тоот тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”
13. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хүүхэд хамгааллын жишиг бодлого”
14. Монгол Улсын БСШУС-ын сайдын 2020 оны 5 сарын 9-ний өдрийн А/269 тоот тушаал “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого”
15. Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 12-р сарын 22-ны өдрийн С/66 дугаар тушаал, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага, MNS 6949. 2021
16. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 12 сарын 31-ний өдрийн А/476 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд ажиллах сэтгэл зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага”
17. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 5 сарын 29-ний өдрийн А/269 тоот тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого”
18. Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж, 2020 он